



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

12
АНГИ

МОНГОЛ ХЭЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 23 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Өүлэн ээж (нийтлэл)

Тэр эх, тэр эмэгтэй хамаг монголын цоо шинэ эхлэл болсон юм. Аз дутсан эрээс нь Есүхэй баатар түүнийг булааж авсан тэр өдөр, тэр цаг, тэр агшинд хээр талын монголчуудын хувь заяа шийдэгдэв. Тэнгэр бурхан Өүлэн эхийг энэ дэлхийд ирүүлэхдээ ганцхан л үүрэг оногдуулсан юм. Тэр нь Чингис хааныг төрүүлэх, түүний эх болох явдал байлаа. Тэрбээр зөвхөн үүний л төлөө алтан дэлхийд төрж, энэ буянт үйлийнх нь төлөө мөнх тэнгэр түүнийг Хамаг Монголын эх болгосон юм. Өүлэн эх бол үл ялагдахын бэлгэдэл, нугаршгүй эзэн Чингис өлмийд нь сөгдөж, аюун эмээдэг ганц хүн байлаа.

Хорвоо хуурамч, Есүхэй баатар мөнх бусыг үзүүлж, өнчин алаг хэдэн үртэйгээ, өндөр олноосоо гээгдэж үлдэхэд далдын ямар сахиус Өүлэнийг аврав аа? Шөнийн харанхуйд эрэг гангын ирмэг дээгүүр явах мэт үхэл хагацлын торгон үзүүрт үе үе хүрэхэд нь хэн аврав аа?

Өүлэн ээж... Өүлэн ээж... гэж хээр талын өвс ногоо гунигтайяа шивнэлдэн найгаж, өндөр тэнгэрт төөрөг татсан намрын өглөө, илчилгүй уудам ертөнцөд нялх балчир хэдэн хүүхэдтэй орхигдсон түүнийг эдүгээ би золоор аврагдсан гэж хэлж чадахгүй. Тэр эх аврагдах, Тэмүүжинийг л аврах ёстой байсан. Тэр үхэж болохгүй байсан. Тэр эхийг Хамаг Монголын халуун амь, хатан сүнс дагаж явсан!

Өүлэн ээж... Өүлэн ээж... гэж хээр талын өвс ногоо ханаран шивнэлдэн найгаж, өргөн Ононы долгис уралдан цалгиж, өлмийг нь аргадсан. Энэ ертөнцөд ирээд ядарсан түүнийг намрын шугуй өрөвдөн шуугьж, шаргал навчсаараа уйлан байсан. Өндөр тэнгэр түүнийг дув дуугүй ширтэж, сэтгэл зүрхний нь гүнд далдын уддисыг шившин шивнэн сэргээж байсан. Тэмүжин... Тэмүжин... Тэмүжин... гэж түгших зүрх нь найман зууны хатуу ханыг нэвтлэн, цаг хугацааны аниргүйд сонстоно. Тэнгэрийн чанадаас бүдэг бадаг цохилох нь тааллаар биеийг олж, бас Тэмүжинийг төрүүлсэн нь түүний амьдралын алтан агшин байлаа. Өүлэн эх амаржсан яг тэр агшинд Монгол улс мөнх тэнгэрийн ивээлээр мэндэлсэн юм.

Тэмүжинд нь Монгол улс, Монгол улс нь Тэмүжин болох он жилүүд тэднийг хүлээж байлаа. Морин төвөргөөн... Морин төвөргөөн... Морин төвөргөөн!... Он жил нисэн өнгөрсөөр, хээр талыг морин төвөргөөн дэлдсээр нэг л мэдэхэд Тэмүжин Монгол улсыг морин дэл дээр хурааж цуглуулсан байлаа.

Тэр цагт түүнийг хамаг олноороо хаан өргөмжилж, Чингис болсон бүлгээ. Энэ нэр салхи шуурганаас хурдан дэлхий дахинаа тархаж, энэ нэрийг сонсоогүй хүн, дуулаагүй амьтан үгүй байлаа. Тэр цагт Өүлэн эх нь гэрийн буурин дээр хэдэн хүүхэдтэйгээ орхигдож, өлөн зэлмэнхэн амь зууж явснаа мартаагүй бүлгээ. Эзэн хаан нь өлсөж үзсэн бол Эзэн хаан нь өнчирч үзсэн бол улс нь өлсөхгүй. Улс нь өнчрөхгүй... Өүлэн эхийн сэтгэлд хөх тэнгэр ингэж шивнэсэн бүлгээ.

Тоо томшгүй алтан зоосыг монгол утсаар хэлхэх шиг ертөнцийн өдөр хоногийг сүвлэн Онон мөрөн мяралзсаар л... Найман зуун жилийг нэвтлэн энэ ижий-мөрөн бидэн рүү урсжээ. Түүнээс өмнө хэчнээн мянга, түмэн жилийг элээсэн ч юм билээ?

Аяа, Онон мөрөн минь Өүлэн эх эрэгт чинь бодлогоширч, хувь заяаны гашуун нулимсаа цалгих долгио таслаагүй урсгалд чинь нэмэрлэн байсныг санана уу? Онон хатан эжий минь, эдүгээ түүнийг урсган оджээ.

Цаг урсаж байна уу, эсхүл хүний амьдрал уу, аль эсхүл Онон мөрөн л урсана уу... Нэхэн санавал Өүлэн хатан ижий нь Онон мөрөн, Онон мөрөн нь Өүлэн хатан ижий ажээ.

Хамаг Монголын эх нь өнчин үрсээ Ононы усаар ундаалсан. Ононы ус хамаг Монголын эхийг, өнчин үрстэй нь ундаалсан! Найман зуун жилийн адагт Өүлэн хатан ижий-Онон мөрөн шиг хамаг Монголыг ундаалсан бус уу?

Тэр эмэгтэй, тэр эх, хамаг монголын цоо шинэ эхлэл болсон юм. Тэнгэр бурхан Өүлэн эхийг энэ дэлхийд төрүүлэхдээ ганцхан л үүрэг оногдуулав. Тэр нь Чингис хааныг төрүүлэх, түүний эх болох явдал байлаа. Тэрбээр зөвхөн үүний төлөө л алтан дэлхийд төрж, энэ буянт үйлийнх нь төлөө тэнгэр түүнийг Хамаг Монголын эх болгосон юм.

О.Дашбалбар

Монгол хэлний даалгаврууд

1. Эхийн нэгдүгээр цогцолборт “**Өүлэн эхэд заяасан их хувь заяаны тухай**” өгүүлсэн бол дөрөвдүгээр цогцолборт юуны тухай байна вэ?
 - A. Өүлэн эх аврагдсан тухай
 - B. Өүлэн эх Тэмүүжинийг төрүүлсэн тухай
 - C. Тэмүүжин Монгол улсыг хураасан тухай
 - D. Тэмүүжиний зовж өссөн тухай
2. “**Өүлэн эх хэцүү бэрхийг даван туулсан**” гэсэн санааг зохиогч аль хэсгээр уншигчдад мэдрүүлсэн бэ?
 - A. Өүлэн эх бол үл ялагдахын бэлгэдэл, нугаршгүй эзэн Чингис өлмийд нь сөгдөж, аюун эмээдэг ганц хүн байлаа.
 - B. Энэ ертөнцөд ирээд ядарсан түүнийг намрын шугуй өрөвдөн шуугьж шаргал навчсаараа уйлан байсан.
 - C. Шөнийн харанхуйд эрэг гангын ирмэг дээгүүр явах мэт үхэл хагацлын торгон үзүүрт үе үе хүрч байв.
 - D. Тэмүүжинийг төрүүлсэн нь түүний амьдралын алтан агшин байлаа.
3. Зохиолч “**Өүлэн эх, Онон мөрөн хоёр нэгссэн**” гэсэн үзэл бодлоо аль хэсэгт илүү тодоор илэрхийлсэн бэ?
 - A. Тоо томшгүй алтан зоосыг монгол утсаар хэлхэх шиг ертөнцийн өдөр хоногийг сүвлэн Онон мөрөн мяралзсаар л...
 - B. Хамаг Монголын эх нь өнчин үрсээ Ононы усаар ундаалсан. Ононы ус хамаг Монголын эхийг, өнчин үрстэй нь ундаалсан!
 - C. Өүлэн эх эрэгт чинь бодлогоширч, хувь заяаны гашуун нулимсаа цалгих долгио таслаагүй урсгалд чинь нэмэрлэн байсан.
 - D. Цаг урсаж байна уу, эсхүл хүний амьдрал уу, аль эсхүл Онон мөрөн л урсана уу...
4. “Өүлэн эх” уран нийтлэл нь “**ухаарал бодролын тухай**” гэж дүгнэе. Тэгвэл энэ дүгнэлтээ аль жишээгээр баталбал илүү хөдөлшгүй болох вэ?
 - A. Тэр эмэгтэй, тэр эх, хамаг монголын цоо шинэ эхлэл болсон юм.
 - B. Тэр үхэж болохгүй байсан. Тэр эхийг Хамаг Монголын халуун амь, хатан сүнс дагаж явсан!
 - C. Нэг л мэдэхэд Тэмүүжин Монгол улсыг морин дэл дээр хурааж цуглуулсан байлаа.
 - D. Найман зуун жилийн адагт Өүлэн хатан ижий-Онон мөрөн шиг хамаг Монголыг ундаалсан бус уу?
5. “Энэ ертөнцөд ирээд ядарсан түүнийг намрын шугуй өрөвдөн шуугьж шаргал навчсаараа уйлан байсан” хэсгээр ямар мэдээлэл өгч байна вэ?
 - A. Шугуй намар болж байгаа талаарх
 - B. Намрын улирал шугуйд хэрхэн ирдэг талаах
 - C. Өүлэн эх хэцүү бэрхийг амссан талаарх
 - D. Өүлэн эх уйлж шантарсан талаарх
6. Эхэд дэвшүүлсэн асуудал юу вэ?
 - A. Өүлэн эх хамаг монголын эх болсон тухай
 - B. Онон мөрний түүхийн тухай
 - C. Онон мөрнөө эх шигээ хайрлах тухай
 - D. Чингис хааны уг гарвалын тухай
7. Аль нь эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэр вэ?
 - A. Энэ буянт үйлийнх нь төлөө тэнгэр түүнийг Хамаг Монголын эх болгосон юм
 - B. Ононы ус хамаг Монголын эхийг, өнчин үрстэй нь ундаалсан!
 - C. Цаг урсаж байна уу, эсхүл хүний амьдрал уу, аль эсхүл Онон мөрөн л урсана уу...
 - D. Найман зуун жилийн адагт Өүлэн хатан ижий-Онон мөрөн шиг хамаг Монголыг ундаалсан бус уу?

14. “технологи” хэмээх гадаад үгийг зөв бичсэнийг олоорой.

A.

ᠲᠡᠬᠡᠨᠠᠯᠠᠭ

B.

ᠲᠡᠬᠡᠨᠠᠯᠠᠭ

C.

ᠲᠡᠬᠡᠨᠠᠯᠠᠭ

D.

ᠲᠡᠬᠡᠨᠠᠯᠠᠭ

15. “Ууртай хүнийг

Ороо морийг” зүйр үгийг гүйцээж бичээрэй.

A.

ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ

B.

ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ

C.

ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ

D.

ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ
ᠲᠡᠭᠦᠨᠠᠭᠤᠯᠠᠭ

Уран зохиолын даалгаврууд

16. Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романы “Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их Тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн нэлээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв” гэсэн хэсгийн хам сэдвийг тодорхойлоорой.

- A. түүхийн хам сэдэв
- B. улс төрийн хам сэдэв
- C. нийгмийн хам сэдэв
- D. шашны хам сэдэв

17. “Дэвхрэг” гэж хэний хоч нэр вэ?

- A. Ч.Галсан “Аянгат цагийн тууж”-ийн Доёбуу
- B. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир”-ын Итгэлт
- C. С.Дашдооров “Бууж мордох хорвоо”-ийн Ангаа
- D. С.Эрдэнэ “Өвгөн шувуу”-ны Жамц

18. Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романы Итгэлтийн хөрөнгөжих эх сурвалж юу вэ?

- A. Эцгээс уламжилсан өв хөрөнгө бага байсан нь
- B. Арван есөн насандаа Лувсан тайжийн охиныг ёслон авсан нь
- C. Лувсан тайжийн охиныг ёслон авч өмчид нь овоо мал авсан нь
- D. Гаднаа цөөн мал байлгаж бусдыг ядуучуудад өгч хариулгадаг нь

19. “Итгэлтийн бүл гэвэл эхнэр Должин, арван настай хүү Хонгор, долоон настай охин Солонго ийм дөрвөн халуун амь билээ” өгүүлбэрт ямар дүрслэх ур маяг байна вэ?

- A. төлөөлөл
- B. адилтгал
- C. тойруулал
- D. юмшуулал

20. “Шүлэглэсэн зохиолын авианы тогтолцоо, түүний загвар, зүй тогтлыг судалдаг шүлэг судлалын салбар ухааныг.....гэнэ” цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

- A. эгшиглэл зүй
- B. бадаглал зүй
- C. айзам зүй
- D. аялгуу зүй

Санамж:

- ✓ Хоёрдугаар хэсэг харгалзуулах даалгавар тул хариултын хуудасны 2-р хэсэгт зааврын дагуу будаж тэмдэглээрэй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Өгүүлбэрийг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|-------------|
| a Тэмээ тэмээ цагаан үүл... | 1 адилтгал |
| b Тэнгэрийн ягаан хаяаг цав суутал ширтлээ... | |
| c Голыг минь гогдон хэлж байна... | 2 хэтрүүлэл |
| d хөгцтэй хад шиг хөх толгой... | |

2.2. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээд хариултын хуудасны 2.2 дугаар хэсэгт хариултаа тэмдэглээрэй.

<p> 1. Өгүүлбэрийн үндсэн үгсийг хариуцаарай. 2. Өгүүлбэрийн үндсэн үгсийг хариуцаарай. 3. Өгүүлбэрийн үндсэн үгсийг хариуцаарай. 4. Өгүүлбэрийн үндсэн үгсийг хариуцаарай. </p>	<p> 1 2 3 4 </p>
---	---

2.3. “гэ-”, “-хэмээ-” язгууртай үгсийн өгүүлбэрт гүйцэтгэх үүргийг зөв харгалзуулаарай.

- | | |
|--|--|
| a Бодовч бодын шийр дөрвөөс хэтрэхгүй гэгчээр Итгэлээс гуйхаас өөр арга олдсонгүй. (Ч.Л) | 1 Хэлц өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбосон |
| b “Нохой хорь!” хэмээн дуудахад айлын хүмүүс цугаар унтсан тул нэлээд удсаны хойно гэрийн дотроос “Хэн бэ?” хэмээн хашхирав. (Д.Н) | 2 Болзох утгаар холбосон |
| c Төмөрөөс үргэсэн сүрэг зээр дээр дээр үсрэн давхиж зугтсанаа гэнэт эргэж, алсаас ирсэн энэ хүнийг таних гэсэн юм шиг баахан харж зогссоноо налайн идшиллээ. (Ч.Л) | 3 Ерийн өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбосон |
| d Ямар юм муухай вэ? гэвэл Үл мэдэгч муухай гэв. (Д.Р) | 4 Өгүүлэгчийн хэлсэн үг өгүүлбэрийг шууд дамжуулсан |